

2015 оны 10 дугаар сард зохион байгуулсан ажлын тайлан

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар

Төрийн байгууллагуудаас хууль, эрх зүйн чиглэлээр сургалт авах төлөвлөгөөний дагуу аймгийн Стандартчлал хэмжил зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Ниймгийн даатгалийн хэлтсүүдээс сургалтыг авч албан хаагчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүллээ.

Газрын хагас жил болон 3 дугаар улирлын тайлангуудад ХШҮнэлгээ хийх ажлыг зохион байгуулав.

Дархан хотын баярыг угтаж байгууллагын хэмжээнд бүтээлч ажлын төлөвлөгөө боловсруулж төлөвлөгөөний дагуу мод тарих, байгууллагын 50 м орчмын газрыг цэвэрлэх, АЗДТГ-аас баталсан хуваарийн дагуу Нэг цонхны үйлчилгээнд оролцож иргэдэд үйлчилэв.

2015 оны 4 дүгээр сард зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийн тайланг ХБХэлтэст хүргүүлэв.

Архивын ерөнхий газраас 2009 онд боловсруулан гаргасан “ORG-AMS” нэртэй архивын бүртгэл, мэдээллийн програмыг байгууллагын бичиг хэргийн компьютерт суулгаснаар гарын авлагын дагуу байгууллагын 2010-2014 оны захирамжлалын баримт бичиг буюу газрын даргын тушаалыг он дарааллаар сканердан ORG-AMS програмд оруулж ажлыг зохион байгуулж байна.

Able программд ирсэн, явуулсан бичиг, өргөдөл гомдлыг скайнердан оруулан шивж системээр ирсэн албан бичиг, захидал бусад мэдээллүүдийг цаг хугацаанд нь хүлээн авч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд “Дархан их хот”-ын баяр нэгдсэн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгууллаа. Энэ арга хэмжээний хүрээнд “Намрын ногоон өдрүүд-2015” арга хэмжээг тус газар нь зохион байгуулж 235 кг зөгийн бал, 200 шил даршилсан ногоо, жимс жимсгэний мод 60 ширхэг нийт 25 төрлийн бүтээгдэхүүнээр 26 иргэн оролцож нийт 4.8 сая төгрөгийн борлуулалт хийж идэвхтэй оролцсон 6 иргэн хоршоог өргөжмлөл үнэ бүхий зүйлээр урамшууллаа.

Мөн жил бүр ХХААЯ-наас зохион байгуулагдаг “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд 17 аймаг, нийслэлийн 6 дүүргийн 250 ногоочин, 4 аж ахуй нэгж, 12 хоршоо, 4 төсөл төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, ногооны үр, модны суулгац эмийн ургамлын бүтээгдэхүүнээр оролцсон. Тус аймгаас нийт 36 иргэн

оролцож нийт зөгийн бал-2140 кг, цэцгийн тоос-10 кг, зөгийн хаалт-9 кг, даршилсан ногоо-530 шил, төмс-2000 кг, хүнсний ногоо-8 төрлийн 3536 кг, жимс жимсгэний мод-18 төрлийн 350 ширхэг суулгац, хатаасан зөгий-3кг нийт 32 төрлийн 8586 кг бүтээгдэхүүнээр оролцож “Зохион байгуулалт сайтай” оролцсон аймгаар шалгарч, Шилдэг сумаар Орхон сум, “Импортыг орлох шилдэг бүтээгдэхүүнээр” Алтан тос ХХК, шилдэг хоршоогоор Орхон сумын “Эрдэнэт зөгий хоршоо” тус тус шалгарч цом, өргөжмлөл, мөнгөн шагналаар шагнагдсан байна.

Хоёр:Салбарын хүрээнд

Мал аж ахуй салбар:

Тус аймгийн хөдөө аж ахуйн бэлтгэл ажлын хангалт болон цаг үеийн мэдээллийг тухай бүр нь гаргаж ХХААЯ болон Аймгийн ХБХ, ОБГ, Захирагчийн албанд 7 хоног бүрийн 4 дэх өдөр шинэчилэн хүргүүлж байна.

Бог малын хээлтүүлгийн ажил эхлээд байна. Хээлтүүлгийн ажилд сумдын МЭҮТасагтай хамтран хяналт тавин ажиллаж байна. Хонгор сумын малчид Дорнод аймгаас 11 толгой Барга үүлдрийн хуц, Дархан сумын 0330 дугаар ангийн туслах аж ахуйд Сүхбаатар аймгаас 6 толгой өсвөр насны Үзэмчин үүлдрийн хуц авчран үржилд ашиглаж байна.

Мөн “Хонь үржүүлэгчдийн холбоо”-ноос 6 Үзэмчин үүлдрийг хуцыг Хонгор суманд үржлийн чиглэлээр бойжуулахаар авчираад байна.

ХХААЯ-ны мал хамгаалах сангийн ажлын хэсэг тус аймагт ажиллан 2010 оноос хойш эрчимжсэн аж ахуйн чиглэлээр зээл, дэмжлэг авсан иргэдийн үйл ажиллагааны ажлын явцтай танилцав. Үүнд: Хонгор сумын саалийн үнээний 1 ферм, Дархан сумын шувууны 2 аж ахуй, гахайн 1, Орхон суманд зөгийн 1 аж ахуйтай тус тус танилцуулан тайланг хүргүүлээд байна.

Мал эмнэлгийн салбар

Шүлхий өвчнөөс эрүүлийг баталгаажуулах шинжилгээг хийх 2 ажлын хэсэг гарч 3 сумын 60 өрхөөс 1200 толгой малын цусны дээж авч дууслаа.Одоо авсан дээжинд Елиза урвалаар шинжилгээ хийж байна.

Гахайн мялзан өвчний тандалт шинжилгээнд Орхон, Дархан, Хонгор сумдын гахайтай өрхүүдээс нийтдээ 90 гахайнаас цус авч ийлдэсийг ялган Улсын мал эмнэлгийн төв лабораторид илгээхээр бэлэн болсон байна.

Бруцеллёзын тарилга хийх ажлыг зохион байгуулснаар 10,6 мянган толгой тугал, 110,2 мянган толгой хурга, ишгийг тарилгад хамруулаад байна.

Намрын тарилга хийсэн акт баримтыг орон нутгийн нэгжүүдээс авч хянан үзэж байна. Одоогийн байдлаар Шарынгол, Орхон, Хонгор сумдын 4 аж ахуй нэгжүүд үндсэн баримт материалаа бүрдүүлэн өгөөд байна.

Хаврын урьдчилан сэргийлэх тарилга хийсэн аж ахуй нэгжүүдийн акт баримтыг бүрдүүлэн санхүүжилтийг нь олгуулахаар аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн боловч, орон нутгийн татварын орлого бүрдээгүйн улмаас одоо хүртэл олгож чадаагүй байна.

3-р улиралын мэдээ, тайланг нэгжүүдээс авч нэгтгэн, МУ-ын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газарт цахим шуудангаар хүргүүлэв.

Газар тариалангийн салбар

Үр тарианы хураалт үндсэндээ дуусч байна. Тухайлбал, энэ онд аймгийн хэмжээнд 14457 га-д буудай, 200 га-д гурвалжин будаа, 4809 га-д тосны ургамал,

528 га-д төмс, 935.2 га-д хүнсний ногоо, 132 га талбайд малын тэжээлийн ургамал тариалалт хийсэн байна. Аймгийн хэмжээнд нийт нутгаар гангийн нөхцөл байдал үүссэн нь таримал ургамлын ургалтанд муугаар нөлөөлж урьдчилсан байдлаар 14.4 мянган га-д үр тариа тариалснаас 3841.5 га ургац алдаж 10349.1 га-аас 7552.9 тонн буюу га-аас 7.3 цн улаан буудай, төмс 2100 тонн, хүнсний ногоо 5618.1 тонн, 672.6 тонн тосны ургамал хураан авахаар тооцоолсон.

Энэ сарын 20-ны байдлаар буудай 640 га-г ангилан хадаж, 640 га-г цайруулан, 4286 га-г шууд хурааж нийт 2830 тонн, төмс 2568 тонн, хүнсний ногоо 3980 тонн, малын тэжээл 1342 тонн ургац хураан аваад байна. Үр тарианы хураалт 47.6 хувь, тосны ургамал 17.2 хувийн гүйцэтгэлтэй, төмс, хүнсний ногооны хувьд хураалт бүрэн дууссан байна.

Хураан авсан ургацыг өнгөрсөн оны гүйцэтгэлтэй харьцуулахад үр тариа 12.2 мянган тонноор, төмс 4.1 мянган тонноор, хүнсний ногоо 10.8 мянган тонноор, тосны ургамал 3.7 мянган тонноор бага харин малын тэжээлийн ургамлын ургац 814 тонноор нэмэгдсэн дүнтэй байна.

Уринш боловсруулалтыг 12500 га хийхээр төлөвлөсөн бөгөөд өнөөдрийн байдлаар 10957.1 га-д буюу 87.6 хувиар гүйцэтгэлтэй байна.

Хүнсний салбар

Монгол улсын хэмжээнд 50 жилийн дараа “Хоол үйлдвэрлэгчдийн улсын II зөвлөгөөн” 2015 оны 09-р сарын 26-28-ны өдрүүдэд Чингисийн талбай, Төрийн ордонд зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд орон нутгийн Тогооч нарын салбар зөвлөлийн үйл ажиллагааг сурталчилсан ба аймгийг төлөөлж оролцсон нийт 46 хүн нээлтийн арга хэмжээний парад жагсаал болон зөвлөгөөнд нэгдсэн зохион байгуулалттай оролцож, санал хүсэлтээ илэрхийлсэн байна.

Улаанбаатар хотод 10 дахь жилдээ зохион байгуулагдаж буй “Намрын ногоон өдрүүд-2015” арга хэмжээ Мишээл экспо худалдааны төвд зохион байгуулагдсан ба Монгол алтан тос, Дархан хүнс ХК, Баян зөгий, Эрдэнэт зөгий, Мишээл бүлэг болон Орхон, Дархан сумын ногоочид, нийт 36 үйлдвэрлэгчдийг хамруулж, мандатыг олгуулж, дотор павилонд 5, гадаа асарт 31 хүнийг байрлууллаа.

Дархан хотын баяр-2015 нэгдсэн үзэсгэлэн худалдаа 2015 оны 9-р сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ба шалгаруулалтын комисст ажиллаж, аймгийн шилдэг брэнд бүтээгдэхүүнүүдийг шалгаруулахад санал хүсэлтээ өгч, үйлдвэрлэл эрхлэгчдэд зөвлөгөө өгч ажилласан байна.

Орхон сумын засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумын засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2015 оны 10-р сарын 20, 21-ний өдрүүдэд Хүнсний тухай, Стандартчилал тохирлын үнэлгээний тухай хуулийн хүрээнд Орхон суманд үйл ажиллагаа явуулж буй 14 хүнсний дэлгүүр, цайны газруудад урьдчилсан хяналт, шалгалт, үнэлгээг хийж, газар дээр нь шаардлага хангахгүй хугацаа дууссан бүтээгдэхүүнийг устгах, буцаалт хийх, үйлдвэрлэсэн огноо тавиагүй бүтээгдэхүүн хүлээн авахгүй байх, бүртгэл хөтлөлтийг хөтлөх, цаашид хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах талаар зөвлөгөө өгч ажилласан байна.

Осол гамшгийн үеийн хүнсний хэрэгцээг бэлэн бүтээгдэхүүн болон боловсруулан хэрэглэх гэсэн 2 төрлөөр тооцон гаргаж, МХГ-т цахим хаягаар хүргүүлсэн байна. Бүтээгдэхүүн нийлүүлэх боломжит хүнсний боловсруулах үйлдвэрийн нэрсийг гаргаад байна. Аймгийн ИТХТ-ийн 2012 оны 40-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулах захирамжийн төслийг МХГ-тай зөвлөлдөн боловсруулаад байна.

Орон нутгийн гурилын үйлдвэрүүдэд намрын ургац хураалтаас хүлээн авсан буудайн хэмжээ, дотоодын лабораторийн шинжилгээний дүнг тухай бүр ХХААЯ-д шууд хүргэх тухай албан тоотыг Өгөөж чанар, Барилтрейд, Таван нуур ХХК-дад хүргэн өгсөн байна. Гурилын 5 үйлдвэрээс үйлдвэрлэлт, борлуулалт үлдэгдлийн мэдээг сард 2 удаа авч байна. Одоогийн байдлаар 2 үйлдвэр буулай татан авах хөрөнгө санхүүгийн эх үүсвэр дутагдалтай, буудай шаардлага хангахгүй гэсэн шалтгаанаар буудай хүлээж аваагүй байна.

БНХАУ-руу мах экспортлоход ХХААЯ-ны хүнсний болон мал эмнэлгийн хэлтэс, МХЕГ, МЭҮГ, Монголын махны холбоо, БНХАУ-ын шинжээчийн багаас бүрдсэн ажлын хэсэг 2015 оны 10-р сарын 02-ны өдөр Дархан меат фүүдс ХХК-ийн мал нядалгааны үйлдвэрийн үйл ажиллагаанд эрсдлийн үнэлгээ хийх ажлыг явууллаа.

Шинэлэг ажил:

1. Орхон сумын ЗДТГ-тай хамтран хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллах талаар хамтран ажиллах удирдамжийг боловсруулж, сумын Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тулгамдсан асуудал

1. Аймгийн ИТХТ-ийн 2012 оны 40-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн үеийн нөөц бүрдүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх ажлын хэсгийг засаг даргын захирамжаар байгуулах

Тайланг нэгтгэсэн: Архив, Бичиг хэргийн эрхлэгч Д.Ганбаяр

Тайланг хянасан: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ

БАТЛАВ: ХХААГ-ЫН ДАРГА

Ц.ЭНХЖАРГАЛ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2015 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Огноо	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
Захиргаа удирдлагын хэлтэс				
1	Байгууллагын нийт албан хаагчдыг бие бялдарын хөгжилт, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох намрын сорилд хамруулах	Сардаа	Б.Бат-Эрдэнэ	Бие бялдарын түвшинг тогтоосон байна.
2	Салбарын тэргүүн болон ХХААЯамны шагналаар шагнуулсан иргэдийн	сардаа	Б.Бат-Эрдэнэ	Шагналууд зохих эздэдээ хүрсэн байна

	шагналуудыг холбогдох газруудад хүргүүлэх.			
3	Байгууллагын ил тод байдлын үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу ажлууд зохион байгуулах.	сардаа	Б.Бат-Эрдэнэ	Байгууллагын ил тод байдал сайжирсан байна.
4	Төрийн байгууллагуудаас хуваарийн дагуу сургалтуудыг авах.	сардаа	Б.Бат-Эрдэнэ	Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.
Мал аж ахуйн хэлтэс				
5	Богийн хээлтүүлгийн мэдээ гаргах	Сардаа	МААХ	Мэдээ үнэн бодит гарсан байна.
6	Монгол мал төрөөс малчдын талаар баримтлах бодлогын тайланг нэгтгэх			Тайланг үнэн зөв гаргасан байна.
7	Малын ээмэгжүүлэлт бэртгэлжүүлэлтийн мэдээг гаргах			Мэдээ, мэдээлэл үнэн зөв бодитой гарсан байна.
Мал эмнэлгийн хэлтэс				
8	Шүлхий өвчнөөс эрүүлийг баталгаажуулах тандалт шинжилгээ хийсэн ажлын болон санхүүгийн тайланг гарган Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид хүргүүлэн үлдэгдэл тооцоог хийх	11-р сарын 20-ны дотор	Мал эмнэлгийн хэлтэс	Тайланг хугацаандаа хүргүүлэх
9	Гахайн мялзангийн тандалт шинжилгээ хийсэн ажлын болон санхүүгийн тайланг гарган Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид хүргүүлэн үлдэгдэл тооцоог хийх	11-р сарын 20-ны дотор		Тайланг хугацаандаа хүргүүлэх
10	Намрын урьдчилан сэргийлэх тарилга хийсэн акт баримтыг хянан үзэж, үндсэн баримтыг бүрдүүлэн аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэн санхүүжилтийг олгуулах	11-р сарын 28-ны дотор		Санхүүжилтийг олгосон байна.

11	Намрын урьдчилан сэргийлэх тарилга хийсэн акт, материалыг анхан шатны нэгжүүдээс бүрдүүлэн авч, хянаж үзэх	11-р сарын 28-ны дотор		Үндсэн баримт материалыг хянан үзсэн байна.
12	Бруцеллёзын тарилга хийсэн үйлчилгээний хөлсний санхүүжилтийг МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газраас шилжүүлэн авах	11-р сарын 25-ны дотор		Санхүүжилтийг шилжүүлэн авсан байна.
13	Цаг үеийн ажилтай холбогдолтой бусад мэдээ, тайланг гаргах	11-р сарын 25-ны дотор		Хугацаандаа гаргасан байна.
Хүнс, газар тариалангийн хэлтэс				
14	Ургац хураалт, уринш боловсруулалтын мэдээг эцэслэн гаргах	Сардаа	ХГТХэлтэс	
15	Чацаргана тариалсан иргэн аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлтийн тайлан гаргах	Сардаа		
16	МХАЭХолбоотой хамтран сургалт зохион байгуулах	11 сарын 04-06 хооронд		